

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

**ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

SAFETY OF BAILIFFS DURING THE COVID-19 PANDEMIC



Э.ЦЭРЭНХАНД

*Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны
сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн
тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад
Мэйл хаяг: E.Tserenkhand@gmail.com*

Товч утга: Цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох шаардлагыг тодорхойлоход чиглэгдэнэ.

Abstract: *It will be aimed at determining the requirements for organizing decisions of a court are obeyed during the pandemic, ensuring the safety of bailiffs, and creating an appropriate legal environment for implementing decisions of a court during the pandemic.*

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгч, цар тахал, төлбөр гаргуулах ажиллагаа, төлбөр төлөгч

Key words: *Security, judgment, enforcement, bailiff, pandemic, recovery, payer*

Удиртгал

Өнгөрсөн 2019 онд үүсэн бий болсон “Ковид-19” цар тахал нь бидний амьдарч дассан дэлхий ертөнцийг болоод хүний амьдарлын хэвшил, дадлыг тэр чигт нь өөрчилсөн томоохон сургамжит цаг үе байлаа. Хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тэдний харилцаа холбоо, нийгмийн зохион байгуулалт ч тэр чигээрээ өөрчлөгдөх шаардлага хүн төрөлхтний өмнө үүсэн бий болсон юм. Хүний нийгэмд шинэ төрлийн харилцаа бий болохын хэрээр түүнээс үүсэх эрх зүйн үр дагавар бүхий тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ даган өөрчлөгддөг жамтай.

Энэ ч агуулгаар хүний аюулгүй байдлын тухай ойлголтод шинэ сорил, шинэ эрсдэл бий болсон гэж үзэж болно.

“Ковид 19” цар тахал хурдацтай тархан, олон улс орон гамшгаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж аюул эрсдэлийг аль болох бага учруулахаар хичээн чармайх болсон нөхцөлд манай улс ч мөн адил нийгмийн амьдралыг хэвийн явуулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, улс орны дотоод хийгээд хүний аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрх зүйн оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн гэж хуульчилсан байдаг⁵. Энэхүү тусгайлсан чиг үүргийнхээ хүрээнд иргэн, захиргаа, зөрчил, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэх үедээ ашигласан эд зүйл, гэмт хэрэг, зөрчил үйлдэх замаар олж авсан хөрөнгө, орлогыг хураах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх ажиллагаа нь ардчилсан нийгмийн үнэт зүйл, үндсэн хуульт байгуулал, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх хамгаалах гол хэрэгсэл болох тул заавал биелэгдэх зүй ёсны шаардлага тулгардаг.

Харин цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэгчдийн аюулгүй байдлын асуудал нь тулгамдсан асуудлын нэг болсон юм. Учир нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээ хязгаар, шүүхийн шийдвэрт заагдсан тодорхой төрлийн үүргийг гүйцэтгэхэд хүний эрх, эрх чөлөөнд хуульд хязгаарлалт тогтоон, төрийн албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хүмүүстэй зайлшгүй уулзах харилцаж үр дүнд хүрдэг онцлогтой.

Иймд цар тахлын үед шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд бий болсон аюул, эрсдэл, тулгамдаж буй асуудлыг нийтэд таниулах, судалгаанд суурилсан шийдвэрлэх саналыг дэвшүүлэх замаар энэ төрлийн харилцааг зохицуулсан эрх зүйн хэмжээг хөгжүүлэх шаардлагатай.

Үндсэн хэсэг

Аюулгүй байдлын шинжлэх ухаан нь байгаль, нийгэм, техникийн шинжлэх ухааны уулзвар дээр бүрэлдэн төлөвшсөн салбар билээ⁶. Энэ агуулгаар аюулгүй байдлын судлагдахуун нь явцуу утгаар бүх хамгийн өргөн хүрээний ойлголт хийгээд хүний амьдрал оршин тогтнохуйд нөлөөлөхүйц бүхий л үзэгдэл, үйл явцыг хамааруулан судладаг билээ.

Хүний эрүүл мэндэд аюултай өвчин эмгэгийг судлах, түүний эсрэг

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017. №24

⁶ Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016. 15 дахь тал.

тэмцэх арга ухааныг нээсэн эртний шинжлэх ухааны салбарыг эрүүл мэндийн шинжлэх ухаан гэх бөгөөд уг салбар шинжлэх ухааны төрлүүд нь бүхэлдээ өөрийн гэсэн эмнэлэг, биологийн аюулгүй байдлын онолыг бий болгосон юм⁷.

Иймд дэлхий нийтэд тулгараад буй онцгой аюул буюу цар тахлын үед төрийн онцгой албаны үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, түүнээс ямар эрсдэл алба хаагчдад учирсныг сонирхоё.

Цар тахал гэж /Pandemic буюу цар тахал нь грек хэлний pan-all-бүх, demos-people-хүн гэсэн үгсийн нийлбэр/ бөгөөд тив, улс дамнасан өргөн хэмжээний нутаг дэвсгэрийг хамрах халдварт өвчнийг ерөнхийд нь нэрлэх олон улсын нэршил юм.

Манай улсын хувьд “Ковид 19” цар тахлын нөлөөгөөр бүх нийтийн бэлэн байдлын зэрэг шилжих болсонтой холбоотойгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, ач холбогдол буурах, шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд эрсдэл учрах зэрэг сөрөг үр дагаварууд ихээхэн бий болсон.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “...төр нь иргэнийхээ зөрчигдсөн эрх, хөндөгдсөн эрх ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх үүрэгтэй⁸” учраас ямарч тохиолдолд шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг ханган ажиллах нь шийдвэр гүйцэтгэгч бүрийн үүрэг юм. Нэг талаас шийдвэр гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэн гэдгийг мөн санах хэрэгтэй.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуульд зааснаар “иргэний болон захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”, “зөрчлийн хэргийн талаархи болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”-г хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг удирдлага болгон чин шударгаар гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэгч юм. Энэхүү ажиллагаа нь ямар тохиолдолд саадгүй хэрэгжих нөхцөл боломжийг хууль тогтоомжоор бататган бэхжүүлэх ёстой.

Монгол Улсын хэмжээнд иргэний болон эрүүгийн хэргийн, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 30 орчим нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улсын хэмжээнд ойролцоогоор 300 шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогыг олж тогтоох, эрэн сурвалжлах, хөрөнгийг битүүмжлэх, хураах, орон байранд нэвтрэх, хөрөнгийг албадан худалдан борлуулах гэх мэт тодорхой төрлийн албадлагыг хэрэгжүүлэх замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг ханган ажиллана.

⁷ Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 9 дэх тал.

⁸ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01

Нэг үгээр шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны байнгын хөдөлгөөн, харилцаанд оршиж үр дүнтэй, бодитой хэрэгждэг ажиллагаа болохыг онцлох хэрэгтэй. Энэ ажиллагаанаас шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд, хамгийн өндөр эрсдэл үүсэж байна.

Иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах хүрээнд шуурхай, тасралтгүй, бүрэн бодитой явагдах зарчмыг бодитой биелүүлэхийн тулд эрсдэлт нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага тулгардаг нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын онцлог бөгөөд цар тахлын буюу гамшигт нөхцөл бий болох үед тус ажиллагааг хэрхэн гүйцэтгэх талаар эрх зүйн болоод практикын шинэ арга журам, туршлага шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Дэлхий нийтэд Covid-19 өвчний халдвараар 631 сая хүн өвчилж, 6.5 сая хүн нас барсан⁹ тохиолдол өнөөдрийн байдлаар бүртгэгдээд байна. Энэ өвчин Монгол Улсад бүртгэгдсэний улмаас 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хатуу хөл хорионы үед шийдвэр гүйцэтгэгч нар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах шаардлагатай болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын “Шинэ төрлийн коронавирус буюу “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө”¹⁰-г 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлан, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажилласан. Энэ нь тухайн харилцааг зохицуулсан цорын ганц эх сурвалж болж байв. Уг төлөвлөгөөнд бэлэн байдлын зэргийг “бэлэн байдал” буюу ногоон, “Өндөржүүлсэн” буюу шар, “Бүрэн өндөржүүлсэн” буюу улаан гэсэн 3 төрөлтэй байхаар зохицуулсан бөгөөд “бэлэн байдал” ногоон дохиогоор ажиллахад авах арга хэмжээг зохицуулсан. Бэлэн байдлын шар болон улаан зэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахгүй байдлаар төлөвлөгдсөн.

Коронавируст халдвар цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахиж /иргэний болон захиргааны, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрт нийцүүлэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах талаар дурдаад Үүнд:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгслийг алба хаагч нэг бүрт олгох, түүнийг тогтмол хэрэглэх, сард 2-оос доошгүй удаа өрөө тасалгаанд ариутгал хийх

⁹ COVID Live - Coronavirus Statistics - Worldometer. <https://www.worldometers.info/coronavirus>

¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Шинэ төрлийн коронавирус буюу “covid-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө” УБ., 2020 он.12 дахь тал.

- Төлбөр төлөгч бусад этгээдийн орон байранд нэвтрэх, хөрөнгө битүүмжлэх хураахдаа халдвар хамгааллын хэрэгслийг тогтмол хэрэглэж, хоорондын зай баримлан ажиллах, Шүүхийн шийдвэрийг үндэслэн орон байр, агуулах, барилга, байшин, чөлөөлөх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулах,

- Ажлын байранд нэвтэрсэн иргэдийн мэдээллийг бүртгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өргөдөл, гомдлыг шуудангаар хүлээн авах

- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг бүртгэл хяналтыг аль болох биечлэн ирүүлэхгүй байх, шаардлагатай тохиолдолд халдвар хамгаалал, хариуцлагыг дээшлүүлж, холбогдох хууль тогтоомжид нийцсэн шийдвэрийг гарган мөрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоож өгсөн байдаг.

Гэвч энэхүү төлөвлөгөө нь шийдвэр гүйцэтгэгч вирусын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн хүнтэй хэрхэн ажиллах, корона вирусын халдвар авсан төлбөр төлөгч, ялтан этгээдтэй хэрхэн харилцах, түүнтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх эрсдэлт нөхцөлд авах арга хэмжээг тусгаагүй байна. Мөн шийдвэр гүйцэтгэгч халдварт өвчний голомтонд байгаагаа мэдсэн үед авах арга хэмжээний талаар зохицуулалтыг дурдаагүй байна. Энэ нь цар тахлын үед явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас алба хаагчид учирч болох эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж чадаагүй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлөвлөгөөгөөр хязгаарлах боломжгүй бөгөөд цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам байхгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулаагүй нь түүний бодит биелэлтэд сөргөөр нөлөөлсөн.

Үүнтэй холбоотойгоор 2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт нь өмнөх оноос 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна¹¹. Ингэснээр иргэдийн зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргах гомдлын тоо өмнөх өнөөс 17 хувиар өссөн нь тус ажиллагааны хэвийн байдал алдагдсаныг гэрчилж байна.

Цар тахлын үед байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэхдээ гэнэтийн нөхцөлд байдалд холбогдуулан бий болгосон төлөвлөгөөгөөр бус, бие даасан эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Эдгээр нь цар тахалтай холбоотойгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч байгууллагын үйл ажиллагаа доголдож, хуулиар

¹¹ Б.Батмөнх. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага зохион байгуулалт магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022. 18 дахь тал

хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирсан нь байгууллагын аюулгүй байдлын асуудал мөн хөндөгдөж байсныг илтгэж байна.

Харин цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед алба хаагч буюу шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал хэрхэн хангагдаж байсныг тодорхойлъя.

Судалгаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын 39 шийдвэр гүйцэтгэгч оролцсон бөгөөд судалгааны асуулгад дараах байдлаар хариулт өгсөн.

“Судалгаанд оролцогчдын 81,6 хувь нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг бол 18,4 хувь нь хорихоос өөр төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг шийдвэр гүйцэтгэгч нар байна. Цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед ажиллах арга зүйн зөвлөгөөг шийдвэр гүйцэтгэгч нарт бүрэн өгсөн, хамгаалах хэрэгсэл /амны хаалт, нэг удаагийн бээлий, улавч, нүүрний хаалт, гар ариутгагч гэх мэт/-ээр хангасан зэрэг нь алба хаагчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлснийг харуулж байна.

Гэхдээ дээрх арга хэмжээнд анхаарах асуудал нэлээдгүй байсаар байна.

Судалгаанд оролцогчын 50 хувь нь ажлаа хийхийн тулд “Ковид 19”-ийн шинжилгээг 4-6 удаа өгсөн бөгөөд тэдний 75 хувь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үедээ цар тахлын халдвар авсан байх магадлалтай гэж хариулсан. Үүнтэй холбогдон гарсан эмчилгээний зардлыг 100% өөрөө хариуцсан ба цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаараа гэр бүл, үр хүүхдэдээ эрсдэл учруулсан гэж 100% санал нэгтгэйгээр хариулсан байна. Харин энэхүү эрсдэлт нөхцөл байдалтай холбоотойгоор учирсан хохирлоо арилгах талаар байгууллагаас арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, өвчтэй, эмчилгээтэй байх үеийн цалинг хасалгүй олгох байдлаар дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн судалгаанд оролцогчид төлбөр төлөгчтэй уулзах, хаягаар явах, хөрөнгө битүүмжлэх, хөндлөнгийн гэрч оролцуулах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүхий л ажиллагааг гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байсныг дурджээ.

Гэтэл энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч хэрэгжүүлээгүй нь хууль тогтоомжид энэ төрлийн харилцааг зохицуулаагүйтэй шууд холбоотой байна. Хэрэв энэ талаар хууль тогтоомжид тусгаж тогтоож өгсөн бол шийдвэр гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардал болон өөрт учирсан хор хохирлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас нөхөн гаргуулах баталгааг эдлэх боломжтой болох юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын гэрээнд шаардлагатай тохиолдолд нэмэлт зардлыг гаргуулах талаар нөхцөл дурдсан байдаг боловч цар тахлын үед буюу гамшигт байдалд ажиллахад шаардлагатай зардлыг гаргуулах талаар зохицуулалт байхгүй,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд энэ талаар зохицуулалт байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт, алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллахад сөрөг нөлөөг үзүүлж байна.

Иймд цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед алба хаагчийг эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах, тэдэнд хохирол, хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, хамгааллын механизм шаардлагатай нь байгааг харуулж байна.

Дүгнэлт

Аюулгүй байдал судлалын асуудал нь өргөн хүрээтэй онолын агуулгыг өөртөө багтаадаг тул хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх биологийн гаралтай аюул, занал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны томоохон салбар болж байна.

Цар тахлын үед ажил үүргээ гүйцэтгэж, ард түмнийхээ аюулгүй байдлыг ханган ажиллах хүндхэн үүрэг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын нуруун дээр ирэв. Энэ хугацаанд үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахын хамт, өөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд цаашлаад ар гэр, үр хүүхэддээ хүртэл аюул, эрсдэл дагуулан очих тохиолдол бидний төрийн тусгай алба хаагч нарт тулгамдаж байсан юм. Энэ асуудал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нарт мөн адил тулгарч байсан бөгөөд энэ асуудлыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай байгааг цар тахлын үед ажиллаж байсан шийдвэр гүйцэтгэгч нар дуу нэгтэйгээр дэмжсэн.

“Ковид 19”-ын тархалтын идэвхитэй үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулж байгаа шийдвэр гүйцэтгэгч нарыг гамшигаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрхэн ажиллах талаар тусгайлсан зохицуулалт бүхий эрх зүйн хэм хэмжээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байхгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан тушаалаар тухайн цаг үед авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө нь иргэний болон захиргаа зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг тооцоолон төлөвлөөгүй байгаа нь цаашид гамшгийн тохиолдол үүсэх бүрт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудал болох эрсдэлтэй байна.

Судалгааны ажлыг бичих явцад цуглуулсан мэдээллээс харахад шүүхээс ирсэн гүйцэтгэх хуудсын тоо 10%-аар өссөн дүнтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 30%-аар буурсан үзүүлэлттэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх иргэдээс ирүүлсэн гомдлын тоо 17%-аар тус тус өссөн тоон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “...төр нь иргэнийхээ зөрчигдсөн эрх, хөндөгдсөн эрх ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх үүрэгтэй” учраас ямарч тохиолдолд шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг ханган ажиллах нь шийдвэр гүйцэтгэгч бүрийн үүрэг юм. Энэхүү үүргээ хэрэгжүүлэхэд төрөөс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хамгаалах чиг үүрэгтэй. Гэвч өнөөдрийн байдлаар цар тахалтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэх нь олон талын дутагдалтай байх бөгөөд цаашид энэхүү харилцааг энэ төлөвлөгөөгөөр зохицуулах боломжгүй юм.

Санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд цар тахал болон гамшигт байдлын үед шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн зохион байгуулах арга, журмыг тодорхойлон тусгах;

2. Цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахад гарсан зардалыг /гэрч, шинжээч оролцуулах, хөрөнгө тээвэрлэхтэй холбоотой зардал г.м/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэмэлт зардалд оруулан тооцдог байх;

3. Цар тахлын үед ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор шинжилгээ өгсөн, хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангагдсан, эмчилгээ хийлгэсэн зардалыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалаас санхүүжүүлэхээр хуульд тусгах;

4. Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гоц халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдолд холбогдон гарах зардлыг байгууллага хариуцах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992 он. №01

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017 он. №24

3. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016.

4. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол арга зүйн асуудал. УБ., 2014

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Шинэ төрлийн коронавирус буюу “covid-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө” УБ., 2020 он.

6. Б.Батмөнх. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага зохион байгуулалт магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022 он

7. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн систем <https://1313.mn/mn/>

8. COVID Live - Coronavirus Statistics – Worldometer. <https://www.worldometers.info/coronavirus>